

## 13

### ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГҮҮД: СУДАЛГААНЫ ЧИГ, СЭДВИЙН МОДУЛИУД

Т.Жааваа, С.Жавзандолгор

Даяаршил, орчны хувьсал нь бүс нутаг, улс гүрний үндэсний хэв шинж, уламжлал, ёс зүй, соёл, зан үйлд их өөрчлөлтийг бий болгож, мэдээлийн технологи, мэргэжлийн бодлого, зохицуулалт, хяналт, судалгааны хөгжилд илт нөлөөлж эхэлсэн. Манайд Азийн хөгжлийн банк, бусад доноруудын дэмжлэгээр “Монгол улсын нягтлан бодох бүртгэл, аудитын ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх нь”, “Засаглалын шинэтгэл - төсвийн нягтлан бодох бүртгэлийн чадавхийг хөгжүүлэх нь” (1993-2006) цуврал төслүүд, шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтаар “Монгол улсын бизнесийн болон ашгийн бус байгууллагын бүртгэл-тайлагнал, аудитын тогтолцоо” (2001), ARC судалгааны төвийн (Солонгос) санхүүгийн дэмжлэгээр “Санхүүгийн тайлан бэлтгэх үзэл баримтлалын зарчим” (2005) сэдэвт гэрээт төслүүд хийгдсэн билээ.

Үндэсний олон судлаач, бүртгэлийн ажилтны хамтын хүч, оролцоотой хийгдсэн эдгээр цуврал төслүүдээр үндэсний нягтлан бодох бүртгэл, аудитын төлөвшил, шинэтгэлийн тойм ба чиг хандлагыг ахисан төвшинд судалж, нягтлан бодох бүртгэл, аудитын мэргэжлийг хөгжүүлэх үзэл баримтлал, төр засгийн бодлогын чиглэлийг томъёолж, Нягтлан бодох бүртгэлийн тухай Төрийн хяналт, Аудитын тухай хуулийн нэмэлтийг зохих байнгын хороодод өргөн барьж, Улсын Их Хурлаар батлуулж, СТОУС, УСНББОУТ-ын хэрэглээг үндэсний хүрээнд хуульчилсан байна.

Судалгааны үр дүнгээр Р.Батжаргал (“Монгол улсын санхүүгийн бүртгэлийн тогтолцоо: аж үйлдвэрийн жишээ”, 1996), Т.Жааваа (“Үндэсний нягтлан бодох бүртгэлийг шинэчлэх асуудалд”, 2003), Ц.Гунгаанямбуу (Санхүүгийн тайлагналын үндэсний стандартын онол арга зүйн тулгамдсан асуудал”, 2006) нар эрдмийн зэрэг хамгаалж, олон арван товхимол, өгүүлэл, илтгэл тавигдан, түүнд мэргэжлийн хувьсал, орчны өөрчлөлтүүдийг тандаж, СТОУС, УСНББОУТ-ын үндэсний хэв шинж, нийцэл ба хамаарлыг загварчлах анхны оролдлогууд хийгдсэн билээ.

(ГЦ) “Монгол улсын бизнес, ашгийн бус байгууллагын бүртгэл-аудитын тогтолцоо” (2001), “Санхүүгийн тайлан бэлтгэх үзэл баримтлалын зарчим” (2005) эрдэм шинжилгээний төслийн тайлан, “Санхүү, өртөг, удирдлагын бүртгэлийн төлөвшил, шинэтгэл дэхь нэн тулгамдсан асуудал” (2002), “Даяар бүртгэлийн давхар бичилтийн түүх” (2004), “Санхүүгийн тайлагнал, удирдлагын бүртгэлийн онол арга зүйн асуудал” (2006) зэрэг нэг сэдэвт товхимол нийтийн хүртээл болсон.

Эдгээр нь Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо (НБОУХ)-ны судалгаа; мэргэжлийн төлөвшилд ёс зүй, соёлын хувьсагчийн нөлөөг судалсан Америкийн судлаачдын (Хофстед Геерт, С.Ж. Грейн) загвар; Австралийн МНБИ-ийн орчны хувьслын судалгаа зэрэг сэтгэлгээ ба арга зүйд суурилжээ. НБОУХ-оос дэлхийн 28 улс гүрний хууль, эдийн засаг, соёлын нөлөөг судлаж, үндэсний хэв шинж, нийцэл ба хамаарлыг загварчилсан нь их сонирхолтой болжээ.

Судлаачдын эдгээр бүтээл, тэрчлэн “Санхүүгийн тайлан бэлтгэх үзэл баримтлалын зарчим” (2005) төслийн хүрээнд “Санхүүгийн тайлан бэлтгэх үзэл баримтлал” олон улсын стандартад хийгдсэн үндэсний тодотгол ба сонголт, заалтын параметр, тайлбарууд нь цаашдын судалгааны эргэлтэд гол сурвалжаар ашиглагдах нь зүйн хэрэг.

Энэхүү суурь стандартын баримт бичгийн үндэсний сонголт ба заалт, тайлбарын параметруудийн (6 бүлэг, 150 зүйл) 2001 оны хувилбарыг (“Санхүүгийн мэдээ” сонин, №22 \58\, №23 \59\, №24 \60\), өргөн хүрээнд хэлэлцэж, 2005 онд Солонгосын ARC төвийн санхүүгийн дэмжлэгээр дахин шинэчилж, эцсийн хэрэглээнд шилжүүлсэн.

Засаглалын шинэтгэл, даяаршилд нэгдэх үзэл баримтлал, англи-сагсоны аккруэл суурьт тогтмол /нэрлэсэн/ үнийн дүнгийн бүртгэл, татварын /нягтлан бодохын/ ашгийн хэмжил зүй, макро эдийн засгийн санхүүгийн харьцааны индикатор, жолоодлогын параметруудийн сонголт, үндэсний хэв шинж ба онцлогууд тусгагдсан. Өнөөдрийг хүртэл манайд хэвшсэн төвлөрсөн бүртгэлийн саармаг тогтолцоог эрс зоримог халж шинэчлэхэд чиглэсэн. Хөндсөн гол санаа, заалтын параметрууд гэвэл:

1. Бизнес, улсын сектор, төрийн бус санхүүгийн тайлагналд олон загвар, хэмжлүүд буй ч англи-сагсоны тогтмол үнийн /нэрлэсэн/ сангийн бүртгэл, түүхэн өртгийн хэмжлийн загвар илт давамгайлах болсон. Гэхдээ өгөгдлийн санг нэмэгдсэн өртгийн хэмжил руу хөрвүүлж, макро эдийн засгийн санхүүгийн харьцааны индикатор, үндэсний тооцооны системийн параметруудийг уялдуулах, санхүүгийн тайлангийн мэдээллийг нийгмийн асуудал (экологи, ажилгүйдэл)-ыг шийдвэрлэхэд ашиглах чиглэлд бүтээлч эрэл эрчимтэй хийгдэх болсон.

2. Дурдсан өгөгдлийн сангуудыг ахиуц орлого, эдийн засгийн параметраар төгсжүүлэх хувиргалтуудыг менежмент бүртгэлийн бүс нутгийн загварууд дэмжиж өгнө. Өгөгдлийн сангийн хувиргалтууд өнөөгийн үнэ цэнэ /PV/, одоогийн өртөг /CC/, зах зээлийн үнэ /SP/, өнөөгийн цэвэр үнэ цэнэ /NPV/, өмчийн үнэ бүрдлийн загвар /CAPM/ суурьт санхүүгийн хэмжилтүүд ба шингээгч зардал /AC/, шууд өртөг /DC/, ажлын захиалга /JC/, үе шат /PC/, стандарт /SC/, үйлдэл суурьт /ABC/ өртгийн систем, суурь, уян хатан төсөв, хариуцлага тайлагнал,

хэлбэлзлийн шинжилгээ, захиалгын оновчтой тоо (EOQ), яг цагт нь (JIT) төсөвлөлт хяналт, нөөцийн менежмент горимтой, үйлдэхүүн, хэрэглэгч, өрсөлдөгчийг тандсан зах зээл, үнийн сегментчлэл суурьт өндөр хурд бүхий маркетингийн мэдээллийн багцуудаар хийгдэнэ.

3. Санхүүгийн тайлан бол хүргэн мэдээлэх хэлбэржүүлж бүтэцчилсэн хэрэглүүр, тэнцэл, орлого үр дүн, санхүүгийн байдлын өөрчлөлт (мөнгөн гүйлгээ, өмчийн хөдлөл), тодруулгын хэсгээс иж бүрдэнэ. Тодруулгын үндсэн горим нь эх сурвалжын тэмдэглэл, хөндлөн лавлагаа, сөрөг тохируулга, дэмжих хүснэгт ба тайлбар мөн. Нэмэлт тодруулгыг заавал тоогоор илэрхийлэх албагүй, хэсэгчлэн буюу бүхэлдээ хүүрнэсэн шинжтэй байж ч болно. Түүнд нэмэлт эх сурвалж, өгөгдөл, график, дэмжих хүснэгтийг хавсаргаж болно. Ийм өгөгдлийн жишээ: бизнес, газар зүйн сегментийн мэдээ, үнийн өөрчлөлтийн нөлөө г.м. Гэхдээ захирлуудын зөвлөлийн тайлан, удирдлагын хэлэлцүүлэг ба шинжилгээ, санхүүгийн үед хамаатай хэвлэл нийтлэл, бусад зүйлс үүнд хамаарахгүй.

4. Хэмжлийн үндэсний хэв шинж ба ялгаа дараах байдлаар илэрнэ. СТОУС хэмжлийн 2 зарчим (Аккруэл суурь, тасралтгүй үйл явц), АНУ-ын Санхүүгийн Бүртгэлийн Стандартын Газар нийтээр зөвшөөрсөн 10 зарчим буюу таамгийг нэр зааж хөнддөг. Тэгвэл түүхэн өртөг, орлого хэрэгжил, хуримтлал хэрэгжилт, уялдуулах, нэмэлт тодруулга, консерватизм, материаллаг шинж гэсэн суурь 7 зарчим, эдийн засгийн тусгаар нэгж, тасралтгүй үйл явц, мөнгөн нэгж, үечилсэн байх, салбарын практик гэгдэх 5 таамаг буюу төсөөллийг үндэсний бизнес ертөнц, улсын секторын эдийн засгийн үнэ цэнэ, тогтмол үнийн бүртгэл ба санхүүгийн тайлагналд мөрдүүлэхээр томъёолж өгсөн.

5. Санхүүгийн бүрдвэр (элемент) – нягтлан бодохын ажил мэргэжилд ажил гүйлгээний хувьсал, санхүүгийн үйл явцын нөлөөллийг эдийн засгийн шинжүүдтэй нь нягт уялдуулсан ерөнхий анги, бүлгийн багц. Онолын бүтцийг хөгжүүлэх чухал хандлага бол энэ багцын хүрээнд элемент, ойлголтын хүрээг тогтоох явдал даруй мөн. СТОУС 5 /хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардал/, АНУ-ын Санхүүгийн Бүртгэлийн Ухагдахууны Тунхагалд 10 бүрдвэр, түүний ойлголт, хүрээг хөндсөн. Ингэхдээ СТОУС олзыг орлогод, гарзыг зардлын ерөнхий багцад шингээж томъёолжээ.

Монгол улсын төсөв, бизнесийн эдийн засгийн үнэ цэнийн хэмжил, тайлагналд хамгийн их холбогдох хөрөнгө, өр төлбөр, өмч, эдийн хөрөнгө оруулалт ба хэрэглээ, орлого, зардал, олз, гарз гэсэн дотоод уялдаа бүхий 9 бүрдэл хэсгийн ойлголт, шинж, шалгуурыг аккруэл суурийн хэрэглээтэй холбож шинээр суулгаж байна.

6. “Санхүүгийн тайлан бэлтгэх үзэл баримтлал” дэхь орлого, зардлын бүдүүвч томъёоллыг үндэсний хүрээнд дараах бүрдэл хэсгүүдээр нарийвчилж байна:

(а) Орлого бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт төсөв ба бизнес хэвийн хувиргалтаар бий болох эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал. Байгууллагын хөрөнгө нэмэгдэж, өр төлбөр багасан, эдийн өмч нэмэгдэнэ.

(б) Зардал бол бараа хүргэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэг төсөв ба бизнес хувиргалт, байнгын үйлдэлтэй холбогдсон гадагш мөнгөн урсгал. Байгууллагын хөрөнгө багасах, өр төлбөр нэмэгдэн, эдийн өмч хорогдох үр дагавартай.

(в) Олз \гарз\ гэж байнгын бус, тохиолдлын ажил гүйлгээ, тэрчилэн эдийн хэрэглээ, хөрөнгө оруулалтаас бусад гүйлгээ, үйл явц, нөхцлийн үр дүнд байгууллагын өмч ба цэвэр хөрөнгөд гарсан өсөлт \бууралт\ гэсэн зарчмын томъёоллууд монгол бүртгэлийн технологид шинээр оруулж буй.

Гэхдээ хөгжлийн энэ зурваст үндэсний судалгаа, хэлэлцүүлгийг шинэ шатанд гаргаж, онол практикийн хувьд уг шинжлэх ухааныг нийгмийн эргэлт, хөдөлгөөнд оруулах цаг болсон, ингэж хөгжүүлэх нийгмийн гарцаагүй эрэлт, захиалгатай бид нүүр тулж ирсэн. Судалгааны чиг, сэдвийн тулгамдсан модулиудын (2007-2020) тухайд:

**Модуль-А:** Аккруэл суурьт тогтмол үнийн бүртгэл, татварын (нягтлан бодохын) ашгийн хэмжлийн загварийг төгсжүүлэх онолын болон сорилын судалгаа: санхүү, татварын бүртгэл, санхүүгийн шинжилгээ, санхүүгийн тайлангийн аудитын аспект

- СТОУС, УСНББОУТ: үндэсний хамаарлын шинжилгээ, загварчлал

- Улсын сектор, бизнес орчны бүртгэлийн загварын тавил ба шийдлүүд

- Макро эдийн засгийн санхүүгийн индикатор, жолоодлогын параметруудийг сайжруулах г.м

**Модуль-В:** Мэдээллийн хэрэглээний чиг хандлагын үүднээс илүү төгс хэмжилтүүд бүхий өгөгдлийн сангийн сүлжээг үүсгэх онолын загвар, эмпирик судалгаа: менежмент бүртгэлийн аспект

**Шаардлага-1:** Менежмент бүртгэлийн динамик хэмжил зүйн хувьсал өөрчлөлтүүд өнөөгийн төсөв, бизнес ертөнц дэхь өрсөлдөөний хувь заяаг шийдэх болсон.

**Шаардлага-2:** Манайд эдийн засгийн /ашгийн/ үнэ цэнийн хэмжлийн төгс хэмжил төлөвшөөгүйгээс үндэсний эргэлтээс хором тутам бид хэдэн сая доллар алдаж буй.

**Шаардлага-3:** Даяаршлын ертөнцөд хариу үйлдэл хийж, дэлхий, бүс нутгийн зах зээлд хүчтэй нэвтрэхийн тулд үндэсний пүүс, компани илүү төгс хэмжилтүүд бүхий өгөгдлийн сан, жолоодлогын параметруудтэй байх ёстой.

**Зорилтот үр дүн:** Эдийн засгийн ашгийн хэмжил, жолоодлогын параметрууд дэхь загварчлал сайжирч, гадагш мөнгөн урсгалын хүлээлтүүд арилж, эдийн засгийн үнэ цэнийг бүрэн өөртөө шингээнэ.

- Менежмент бүртгэлийн бүсүүдийн (Ази, Америк, Европ) моделиудыг анхааралтай судалж, хувьслуудад хариу үйлдэл хийх

- Үндэсний маркетингийн стратеги, менежмент философийг тэтгэх мэдээллийн сүлжээний (динамик) тавил, түүний шийдэл, горимын саналуудыг дэвшүүлэх

- Шугаман үйлдэл, зардлын урсгалын инженеринг, АВС өртгийн систем гэх мэт төгс загварчлал ба системийн сүлжээг сайжруулах чиглэлийг түлхүү хөндөж тавих

**Модуль-С:** Олон улсын судалгааны дараах нэн сонирхолтой сэдвүүдэд хүчээ сорьж, үндэсний дуу хоолойг өргөх өргөн боломж бий:

- Мэргэжлийн түүх, цаг тооллын аспект (мөнгө, хадны зураг г.м)
- Корпорацийн тайлан, нэмэгдсэн өртгийн хэмжлийн загвар
- Хүний нөөц, мэдлэг менежмент, оюуны өмчийн хэмжил зүй
- Эдийн засгийн үнэ цэнийн хэмжлийн загварчлал
- Бичил хэмжил зүй, өгөгдлийн сангийн хувиргалтын парадигмүүд

Мэдээллийн татвар, иргэний эрх, ёс зүйн хэв шинж төдийгүй хэрэглэгчийн зан үйл, хөдлөл, сэтгэл зүйн талыг хөндсөн сэтгэлгээний персоналист, бихевиорист чиг урсгал, холбоос ба хамаарлын нөлөөг судлах нь их чухалд тавигдаж байна. Хэрэглээний хандлагын үүднээс алив мэдээлэл удирдлагын шийд гаргагч бүлгүүдийн зан үйл, сэтгэл зүй, үйл хөдлөлийг залж, тэдний зүгээс хийх хариу үйлдлийн өдөөгч байх тухай сүүлийн үес бичих болжээ. *Эндээс үзвэл үндэсний төдийгүй олон улсын төвшинд хүч сорьж, дуу хоолой нэгтгэх судалгаа хөгжлийн нэн сонирхолтой сэдэв ба сайжруулалтууд, ээдрээтэй, оньсыг нь тайлах зүйлс олон байна.*